

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

### Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Батлагдсан тарифыг 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Хөвсгөл дулааны станц” ТӨХК /Д.Цанлигрэнчин/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тариф, зах зээлийн газар /Б.Болор-Эрдэнэ/-т даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 231, 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 382, 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 384 дүгээр тогтоолуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

Б.БАТТУЛГА

ЗОХИЦУУЛАГЧ

У.МЯГМАРСҮРЭН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.САМДАН

*Эрчим хүчний зохицуулах хорооны  
2021 оны ... дүгээр сарын ...ны өдрийн  
... дүгээр тогтоолын хавсралт*

## ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ

1. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/	
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м <sup>3</sup>	1,560.0	
2	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/ГЖ	17,758.5
		тогтмол	Төг/м <sup>3</sup>	1,057.2
3	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м <sup>3</sup>	1,200.0	
4	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/ГЖ	13,660.4
		тогтмол	Төг/м <sup>3</sup>	813.3
5	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "0" –ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м <sup>2</sup>	600.0	
6	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/хүн	6,000.0	
		Төг/м <sup>3</sup>	3,000.0	
7	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	41 м <sup>2</sup> хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	3,000.0
		41 м <sup>2</sup> - 81 м <sup>2</sup> хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	5,000.0
		81 м <sup>2</sup> -аас дээш талбайтай айл өрх	Төг/сар	10,000.0